

“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН-ИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

1. Зорилго

- 1.1. “Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН /цаашид “**Нөхөрлөл**” гэх/ нь Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 2011 онд баталсан “Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмууд”, 2015 онд баталсан “Тогтвортой Хөгжлийн Зорилтууд” болон хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, зөрчихгүй байхад бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх чиг хандлагын хүрээнд хүүхдийн эрхийг дээдлэгч хамт олон байж, хүүхдийг хүндэтгэсэн нийгмийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор энэхүү Хүүхдийн эрхийг хангах бодлогын баримт бичиг /цаашид “**Бодлого**” гэх/-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.
- 1.2. Нөхөрлөл нь хүүхдийн эрхийг хангах, зөрчихгүй байх, зөрчихөөс урьдчилан сэргийлэх үүднээс нөхөрлөлийн дотоод болон Үйлчлүүлэгч буюу гадагш чиглэсэн үйл ажиллагаандаа НҮБ-ын Хүүхдийн сангаас баталсан Хүүхдийн эрх, бизнесийн зарчмуудыг баримтална.

2. Нэр томьёо

- 2.1. Энэхүү Бодлогод заасан нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - a. “Ажил олгогч” гэж Нөхөрлөл, Нөхөрлөлийн гишүүдийг;
 - b. “Хүүхэд” гэж 18-аас доош насны хүнийг;
 - c. “Бага насны хүүхэд” гэж 12 хүртэлх насны хүнийг;
 - d. “Хүүхэд хамгаалал” гэж хүчирхийлэл, үл хайхрах, дарамт, мөлжлөгийн улмаас учрах хор хөнөөлөөс хүүхдийг нийгмийн бүхий л орчинд хамгаалах явдлыг.

3. Дотооддоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1. Нөхөрлөл нь хүүхдийн эрхийг хангах, зөрчихгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дотооддоо дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - a. Ажилтны үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр:
 - i. Нөхөрлөл нь Бага насны хүүхэдтэй ажилтан цагийг Хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор сар бүрийн ажлын нэг өдөр буюу ажлын 8 цагийг “Хүүхдийн өдөр” болгоно.
 - a. Нөхөрлөл нь Хүүхдийн өдөр Бага насны хүүхэдтэй ажилтанд цалинтай чөлөө олгоно;
 - b. Хүүхдийн өдрийг Бага насны хүүхэдтэй ажилтны хүсэлтийг харгалзан Ажил олгогч тогтооно. Хүүхдийн өдрийг Ажил олгогчоос

тогтоосон өдөр авах боломжгүй тохиолдолд хэдийд авах тухай саналаа Ажил олгогчид ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө урьдчилан мэдэгдэх бөгөөд ажлын ачаалал, тухайн Бага насны хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан Ажил олгогч тухай бүр шийдвэрлэнэ;

- c. Бага насны хүүхэд нь цэцэрлэг, сургуульд явдаг зэрэг бусад шалтгааны улмаас Хүүхдийн өдрийг ажлын нэг өдөр авах боломжгүй/шаардлагагүй тохиолдолд тухайн сарын ажлын 8 цагийг ямар хуваариар авах тухай саналаа Ажил олгогчид урьдчилан мэдэгдэх бөгөөд Ажил олгогч хуваарийг эцэслэн шийдвэрлэнэ.
 - d. Ажилтан Хүүхдийн өдрийг зөвхөн хүүхдэдээ зориулах бөгөөд зураг, бичлэг хийх зэргээр хүүхэдтэйгээ хэрхэн ажилласнаа Ажил олгогчид товч тайлагнана.
- ii. Нөхөрлөл нь Бага насны хүүхэдтэй ажилтныг уян хатан цагийн хувиараар ажиллах боломжоор хангах бөгөөд ажилтны саналыг харгалзан ажлын цагийн хуваарьт оруулж болно.
 - iii. Хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл сургуульд эхлэн суралцагч Бага насны хүүхдэдээ суралцах болон бусад дадлыг бий болгох гэх мэт шалтгаантай Ажилтанд тодорхой хугацаанд нэмэлт чөлөө олгох, богиносгосон болон уян хатан цагийн хуваарийн дагуу ажиллуулах зэрэг боломжийг тухайн ажилтны санал, хүсэлтийг үндэслэн Ажил олгогчоос шийдвэрлэж болно.
 - iv. Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгааллын асуудлаар төрийн байгууллага, хуулийн этгээдээс зохион байгуулсан арга хэмжээнд оролцоход эцэг, эхэд цалинтай чөлөө олгож болно.
- b. Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбогдуулан авах арга хэмжээний хүрээнд
 - i. Нөхөрлөл нь Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил гаргасан хүнийг ажилд авахгүй байхыг эрмэлзэнэ. Шаардлагатай гэж үзвэл нь зөвхөн энэ асуудлаар Цагдаагийн байгууллагын тодорхойлолт гаргуулж ирэхийг ажилд горилогчид санал болгож болно.
 - c. Ажил хэргийн зорилгоор хүүхдийн дуу, дүрс, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд ашиглах хүрээнд
 - i. Хүүхэд хувийн амьдрал, нууцлалаа хамгаалуулах эрхтэй бөгөөд хүүхдийн эмзэг байдлыг хэвлэл мэдээлэлд ашиглахад түүнийг дахин хохирогч болгох эрсдэлтэй байдаг тул Нөхөрлөл нь энэ асуудалд болгоомжтой хандана.
 - ii. Нөхөрлөл нь энэ үйл ажиллагаанд дараах журмыг мөрдөнө:
 - a. Хүүхдийн дуу, дүрс болон хүүхдийн тухай мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ашиглахдаа хүүхэд бүрийн нэр, нэр төрийг нэн тэргүүнд тавина;
 - b. Тухайн хүүхдийн дуу, дүрс болон холбогдох мэдээллийг ашигласны улмаас тухайн хүүхдийн бие мах бодь болон нэр төрд учирч болох

аливаа эрсдэл, үүний дотор анги хамт олон, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхгүй байх, гадуурхалтын золиос болох эрсдэл байгаа эсэхийг нягталж, товч тайланг бичгээр үйлдэнэ;

- c. Хүүхдийн зургийг авах, дуу, дүрсний бичлэг хийхийн өмнө хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авах бөгөөд хаана, хэрхэн ашиглахыг тайлбарлана;
- d. Хүүхдийн зураг, дуу, дүрсний бичлэг нь хүүхдэд хүндэтгэлтэй хандсан байгаа эсэхийг хянана. Хүүхэд тохиромжтой хувцасласан байхад анхаарна;
- e. Тухайн зураг нь тухайн сэдэв, үйл явдлын үнэн зөв төлөөлөл болж байгаа эсэхийг нягтална;
- f. Хүүхэд гудамж, асрамж халамжийн төвд амьдардаг, эсхүл эрх нь зөрчигдсөн зэрэг эмзэг, эрсдэлтэй байдлын талаар дуу, дүрс, мэдээлэл ашиглахыг хориглоно.

d. **Нөхөрлөлийн дотооддоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд**

- i. Хүүхдийн хүүхэд байх эрх (the right to a childhood). Нөхөрлөл нь хүүхэд байх эрхийг хангах үүднээс Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон Шинэ жил зэрэг баярын өдрүүдэд хүүхдийг “хүүхэд” байгаа гэдгийг нь мэдрүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна. Ингэхдээ хүүхдийн эрүүл мэнд, өсөлт бойжилтод сөргөөр нөлөөлөх агууламж бүхий бэлэг, хүнс, хүнсний болон бусад бүтээгдэхүүн ашиглахаас зайлсхийнэ.
- ii. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах. Нөхөрлөлийн ажлын байранд Бага насны хүүхэд авч ирэх тохиолдолд тэдгээрийн аюулгүй байдлыг эцэг, эх, асран хамгаалагч нь хариуцна.
 - a. Бага насны хүүхдийг аль нэг өрөөнд аюулгүй байлгах боломжоор хангахыг эрмэлзэнэ;
 - b. Бага насны хүүхдийг ус, чихрийн агууламж багатай ундаа, жигнэмэг зэрэг зүйлсээр дайлах бөгөөд хүүхэд бусад ажилтанд болон байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх нөхцөлийг эцэг, эх, асран хамгаалагч нь бүрдүүлнэ.
- iii. Нөхөрлөл нь хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр мэргэших сонирхолтой Ажилтныг хөхиүлэн дэмжинэ.

4. Үйлчлүүлэгч буюу гадагш чиглэсэн үйл ажиллагаа

4.1. Нөхөрлөл нь хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, зөрчихгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажил, үйлчилгээндээ дараах гадагш чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- a. Хүүхдийн хууль бус хөдөлмөр эрхлэлтийг эсэргүүцэх, түүнтэй тэмцэх хүрээнд:
 - i. Нөхөрлөл нь хүүхдээр хууль бус хөдөлмөр эрхлүүлдэг байгууллагатай хамтран ажиллахгүй бөгөөд тийм байгууллагаас бараа, үйлчилгээ авахгүй.

- a. Нөхөрлөл нь аливаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс худалдан авалт хийхийн өмнө хүүхдээр хууль бус хөдөлмөр эрхлүүлж байгаа эсэх талаар ажиглалт, боломжит тодруулга, тандан судалгааг авна;
 - b. Хамтран ажиллах, худалдан авалт хийх иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь хүүхдээр хууль бус хөдөлмөр эрхлүүлж байгаа, эсхүл тийм бодит эргэлзээ байгаа бол энэ талаар тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтантай уулзаж уг үйл ажиллагаа нь хуулиар зөвшөөрөгдөөгүй бөгөөд түүнийг хэрхэн арилгах талаар товч зөвлөгөө өгнө. Хэрэв уг зөвлөгөөг хүлээн авах, эсхүл уг нөхцөл байдлыг нэн даруй арилгах талаар санал, санаачилга гаргаагүй бол үйлчилгээ үзүүлэх, худалдан авалт хийхээс татгалзана.
- b. Хүүхэд хамгааллын талаар олон нийтэд мэдээлэл түгээх хүрээнд
- i. Хүүхэд хамгаалал болон хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар олон нийтийн дадал, зан үйлийг өөрчлөх мэдлэг, мэдээлэл, сурталчилгаа, сургалтын арга зүй боловсруулан, түгээнэ.
 - ii. Хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих явдлыг үл тэвчих нийгмийн хандлага төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна.
 - a. Энэ хүрээнд цахим болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхэд хамгааллын талаар мэдээ мэдээлэл, контент бэлтгэж түгээх, нийгэмд нөлөө үзүүлэх цахим хөдөлгөөн өрнүүлэх зэрэг ажлууд зохион байгуулна;
 - b. Нөхөрлөлийн цахим хуудаст хүүхдийн эрхийн булан ажиллуулах бөгөөд түүгээр дамжуулан хүүхэд хамгааллын талаар мэдээ, мэдээлэл хүргэнэ;
 - c. Нийгэмд чиглэсэн бусад үйл ажиллагаанд хамрагдаж, хэрэгжүүлнэ.
- c. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хүрээнд
- i. Нөхөрлөл нь хууль зүйн үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчид хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар шаардлагатай мэдээ мэдээлэл өгөх буюу зөвлөнө.
 - a. Нөхөрлөл нь хууль зүйн үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн эрх, хүүхдийн хууль бус хөдөлмөр эрхлэлт, хүүхэд хамгааллын талаар мэдээллийг үйлчлүүлэгчид өгөх бөгөөд Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийг хангах тухай мэдэгдлийг хавсаргана.
 - b. Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчид энэ талаар нэмэлт зөвлөгөө, мэдээлэл өгөх бөгөөд үйлчлүүлэгчийн хүсэлтээр хүүхдийн эрхийн дотоод баримт бичгийн төсөл боловсруулах болон холбогдох нэмэлт үйлчилгээг санал болгож болно.
 - ii. Хүүхдийн эрхийг хамгаалах холбогдох стандарт боловсруулж, санал болгоно.

5. Ажилтны хүлээх үүрэг

5.1. Энэхүү Бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Нөхөрлөлийн Ажилтан нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- a. Ажил үүргээ гүйцэтгэж байх үед тохиолдсон эсэхээс үл хамааран аливаа этгээдийн зүгээс хүүхдийн эсрэг бие махбод, сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, эдийн засгийн болон бэлгийн мөлжлөгт оруулсан, 18 насанд хүрээгүй Хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон, хүүхдийн эсрэг бие махбод, сэтгэл санааны шийтгэл хэрэглэсэн, хүүхдийг дарамталсан, хүүхдээ үл хайхран үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээ биелүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн тохиолдолд хүүхэд хамгааллын, цагдаагийн болон эрх бүхий бусад байгууллагад нэн даруй мэдээлнэ;
- b. Ажлын байранд ирсэн Бага насны хүүхэдтэй найрсаг, хүндэтгэлтэй харилцана;
- c. Иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас худалдан авалт хийхийн өмнө хүүхдээр хууль бус хөдөлмөр эрхлүүлж байгаа эсэхэд ажиглалт хийж, хүүхдийн хууль бус хөдөлмөр эрхлэлтийн талаар боломжит тодруулга, тандан судалгааг авна; Хүүхдээр хууль бус хөдөлмөр эрхлүүлж байгаа, эсхүл тийм бодит эргэлзээ байгаа бол тухайн иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс худалдан авалт хийхээс аль болох татгалзана.
- d. Хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, таниулан сурталчлах бүх төрлийн ажилд идэвхтэй оролцож, Үйлчлүүлэгчид шаардлагатай хууль зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлнэ.

6. Хариуцлага

- 6.1. Энэхүү Бодлогыг Нөхөрлөлийн үндсэн, гэрээт, цагийн болон дадлагын зэрэг бүх ажилтан баримтална. Нөхөрлөлийн ажилтан хүүхдийн эрхийн эсрэг үйл ажиллагаа явуулсан бол зөрчил, дутагдлын үр дагавар, учруулсан хохирлын хэмжээнээс хамаарч Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Нөхөрлөлийн дотоод журам болон холбогдох бусад хуульд заасны дагуу сахилгын, захиргааны хариуцлага хүлээлгэх буюу эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж болно.
- 6.2. Энэхүү Бодлогыг зөрчсөн тохиолдолд эрүүгийн, эсхүл захиргааны хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран тухайн ажилтныг хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасанд тооцно.